

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨР  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 05 дугаар сарын 07





Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
1	<p><b>Үүрэг, даалгавар НЭГ:</b> Засгийн газраас 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан 2026 онд шинээр баригдах Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн байршил, хамран сургах тойрог, хамрагдах хүүхдийн тоо зэргийг нарийвчлан тодорхойлж, газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцаж ажиллах.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан 2026 онд шинээр баригдах болон баригдаж буй Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн байршлыг гаргах, тухайн байршлууд дээр очиж нөхцөл байдалтай нь танилцах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс, Газар зохион байгуулалтын алба, Боловсролын хэлтсээс хамтран ажиллахаар төлөвлөж байна. Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлуудтай явж танилцахад дүүргийн 8 дугаар хорооны 640 хүүхдийн суудал бүхий сургуулийн барилгын гүйцэтгэл 25%, 12 дугаар хорооны 240 хүүхдийн суудалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын гүйцэтгэл 90%, 19 дүгээр хорооны 240 хүүхдийн суудалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын гүйцэтгэл 70%-тай байгаа ба дүүргийн 13, 17, 23 дугаар хороодод шинээр сургууль, цэцэрлэг барихаар газар чөлөөлөлтийн ажил явагдаж байна. Хамран сургах тойргийн мэдээллийг дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нар, сургууль, цэцэрлэгийн удирдлагуудын хамт хуралдаж, протоколоор саналаа баталгаажуулан албан бичгээр ирүүлдэг боловч энэ хичээлийн жилд дүүрэгт шинээр хороо нэмэгдээгүй тул саналыг өмнөх жилийн хувилбараар Нийслэлийн Боловсролын газарт хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн дүүргийн нутаг дэвсгэрт дахин төлөвлөлтийн хүрээнд газар чөлөөлөлтийн ажил хийгдсэн, төвийн хэсгийн хуучин суурьшлын бүсэд аж ахуйн нэгж, байгууллага төвлөрсөн зэргээс шалтгаалан тус хэсэгт байрлах хүүхдийн цэцэрлэгийн элсэлт буурсан, үндсэн хүчин чадлаас бага ачааллаар хичээллэх нөхцөл үүсэж байгаа зэрэг саналуудыг нэгтгэж, Нийслэлийн Боловсролын газарт хүргүүлж ажилласан.</p>			70

<b>Үүрэг, даалгавар ЗУРГАА:</b> Нийтийн эзэмшлийн гудамж, явган хүний зам талбайд удаан хугацаанд байршуулсан автомашиныг журамлах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах.			
2	Дүүргийн нутаг дэвсгэрийн 1-24 дүгээр хороодын гудамж талбайд үзлэг шалгалт хийж, нийтийн эзэмшлийн автомашины зогсоол, талбайд удаан хугацаагаар зогссон нийт 38 зөрчлийг баримтжуулан 28 тээврийн хэрэгслийн эзэмшигчтэй холбогдож зогсоол талбайг чөлөөлөх арга хэмжээ авч, 10 тээврийн хэрэгслийн эзэн холбогдогч тогтоогдохгүй тээврийн хэрэгслийг "Бат зэв" ХХК, "Булган жац" ХХК-ний журмын хашаатай хамтран тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.		100
<b>Үүрэг, даалгавар НАЙМ:</b> Нийслэлийн Засаг даргаас хороодын Засаг дарга нарт өгсөн үүрэг даалгавар, түүний хэрэгжилтийн тайланг сонсох ажлыг зохион байгуулах.			
3	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хороо болон Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсээс нийт 31 үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.		100
<b>Үүрэг, даалгавар АРАВ:</b> Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/379, А/509 дүгээр захирамжийн хүрээнд дүүргийн төсвийн орлого бүрдүүлэх ажлыг эрчимжүүлж, татварын ногдол, өрийг төсөвт төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтэд Санхүү, хөрөнгө оруулалтын газар хяналт тавьж, үр дүнг танилцуулах.			
4	<p>2025 оны 05 дугаар сарын 05-ны байдлаар өссөн дүнгээр:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Улсын төсөвт 48,138,538.92 мянган төгрөг төвлөрүүлэхээс 43,546,616.71 мянган төгрөг төвлөрүүлж 90.46%</li> <li>➢ Нийслэлийн төсөвт 12,216,405.65 мянган төгрөг төвлөрүүлэхээс 7,248,069.66 мянган төгрөг төвлөрүүлж 59.33%</li> <li>➢ Дүүргийн төсөвт 112,332,686.00 мянган төгрөг төвлөрүүлэхээс 88,013,673.65 мянган төгрөг төвлөрүүлж 78.35%-ийн биелэлттэй байна.</li> </ul> <p>Тайлант оны ертэй 493 татвар төлөгчийн 23,074,355.71 мянган төгрөгийн өр, ногдлыг төлүүлэхээр нэхэмжлэх хүргүүлэн утсаар холбогдож 186 татвар төлөгчийн 592,579.05 мянган төгрөгийн өрийг барагдуулан ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд 2 удаагийн давтамжтай 14874 татвар төлөгчдөд 2024 оны "ХХОАТ-ын тайлангийн ирц хангуулах тухай" "САНУУЛАХ" масс мессеж хүргүүлж, Татварын Ерөнхий газраас бэлтгэн гаргасан мэдээ мэдээллийг хэлтсийн пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр тогтмол түгээн хариуцсан зах, худалдааны 12 төвөөр тайлангийн ирц хангуулах, зөвлөгөө өгөн сургалт зохион байгуулж, "Татварын шинэчлэл-2025" санал асуулгад 100% хамруулж ажиллаж байна.</p>		70

<p><b>Үүрэг, даалгавар АРВАН ГУРАВ:</b> Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1, 13.2-т заасны дагуу 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс хойш хөрөнгө оруулалтын ажилд шинээр гэрээ байгуулах боломжгүй болж байгаатай холбогдуулан худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх.</p>			
<p>5</p>	<p>Нийслэлийн Засаг даргаас эрх шилжиж ирсэн 4 ажил болон 2025 онд Чингэлтэй дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 199 төсөл арга хэмжээнээс 122 ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулан, 35 ажил гэрээ байгуулан хэрэгжиж байна. Үлдсэн 46 ажил нь зураг төсөл боловсруулах, холбогдох байгууллагуудтай зөвшилцөх, ажлын даалгавар, техникийн нөхцөл хүсэх шатандаа явж байгаа бөгөөд 2025 оны 05 дугаар 31-ний өдөрт үлдсэн ажлуудыг багтааж худалдан авах ажиллагааг явуулах талаар ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.</p>	<p>50</p>	
<p><b>Үүрэг, даалгавар АРВАН ТАВ:</b></p>	<p>Нийслэлийн хэмжээнд соёлын үнэт зүйлсийг өвлүүлэн эзэмшүүлэх, түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг хамгаалж, урлаг, соёлын үзвэр, үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах.</p>		
<p>6</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн 9 дүүргийн дунд зохион байгуулсан “Өвлийн фестивал” арга хэмжээнд дүүргийн 200 гаруй ажилтан, албан хаагч, иргэдийг хамруулж, тэргүүн байрт шалгарсан амжилтыг үзүүлсэн.</li> <li>- Б.Явуухулангийн нэрэмжит яруу найргийн тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, дүүргийн Ерөнхий боловсролын 15 сургуулийн 30 гаруй сурагчид хамрагдсан. Мөн 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдөр яруу найргийн дурсамж, өдөрлөгийг Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулсан.</li> <li>- Дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлагуудад хүүхэд багачуудын бие даалтын 7 хоногт музейн үзвэрээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх боломжтой талаар болон Хүүхэлдэйн театраас сургуулийн амралтыг тохиолдуулан төлбөрийн 30% хөнгөлөлттэй үнээр үйлчилж байгаа мэдээллийг хүргэж ажилласан.</li> <li>- “Угийн бичиг хөтлөх арга зүйн сургалт”-ыг 2025 оны 03 дугаар сарын 27-ноос эхлэн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд хуваарийн дагуу дүүргийн 1-24 дүгээр хороодод 10 удаа зохион байгуулж, нийт 500 гаруй иргэн хамрагдаж, гарын авлага тараасан.</li> <li>- Соёлын биет бус өв болох уртын дуу, бий биелгээг дэлгэрүүлэх, таниулан сурталчлах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Завсарлагааны дуу, бүжиг” аяныг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд өрнүүлж, Ерөнхий боловсролын нийт 18 сургуулийн 12000 гаруй хүүхэд хамрагдсан.</li> <li>- Ардын уран зохиолч Дэндэвийн Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол” шүлгийг нэг цагт, нэгэн зэрэг унших арга хэмжээг Чингэлтэй дүүрэгт “Тусгаар тогтнол”-ын талбайд 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 12:00 цагт зохион байгуулсан.</li> </ul>	<p>100</p>	

	<p>- Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Монголын Үндэсний бөхийн холбоотой хамтран "Чингэлтэй хайрхны хишиг барилдаан"-ыг 2025 оны 05 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>- "Аугаа эх орны ялалтын 80 жил"-ийн ойг угтан Тусгаар тогтнолын талбайд 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулсан.</p>		
	<p><b>Үүрэг, даалгавар АРВАН ЗУРГАА:</b> Авто замын тэмдэг, тэмдэглэгээг шинэчлэх, засварлах, байршуулах ажлуудаа эрчимжүүлж ажиллах.</p>		100
7	<p>Дүүргийн нутаг дэвсгэрийн гудамжны замын тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг шалгалт хийж, хандалт буруу, хазайсан, буруу газар байрлуулсан тэмдгийн мэдээллийг авч Нийслэлийн Замын хөгжлийн газарт хүргүүлсэн. Гүйцэтгэгч байгууллага болох "Гэрэлт зам ундарга" ХХК-иар дүүргийн 1-24 дүгээр хороодын нийт 195 тэмдгийн арчлалт, хураан авалт, эвдэрч гэмтсэн тэмдгийн засвар үйлчилгээг хийлгэж, 39 тэмдэг суурилуулан ажилласан.</p>		
	<p><b>Үүрэг, даалгавар АРВАН НАЙМ:</b> Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрлийн болон бусад шон дээгүүр татсан кабел утас, өнгө үзэмжгүй самбар зэргийг цэгцлэх ажлуудыг шуурхай зохион байгуулах.</p>		
8	<p>Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ хариуцсан "Соёндрим" ХХК гэрэлтүүлгийн шон дээр татсан эзэмшигч, ашиглагч нь тодорхойгүй 210 м кабелин утсыг сойж, 25 шон дээр наасан сурталчилгааны хуудсыг хуулсан.</p>		70
			<p>Төв замын гэрэлтүүлэг хариуцсан "Энержи комплекс" ХХК нь төмөрчний гудамжны төв зам дагуу 6 ширхэг гэрэлтүүлгийн шон дээр байрлуулсан 14 ширхэг сурталчилгааны самбарыг буулгаж, эзэмшигч ашиглагч нь тодорхойгүй 30 м кабель утсыг цэгцэлж сойсон.</p>

				<p><b>Үүрэг, даалгавар АРВАН ЕС:</b> Нийслэлийн хэмжээнд ой, хээрийн түймэр, ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтэд сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>Ой, хээрийн болон шар өвсний гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх хүрээнд дүүргийн 24 дүгээр хороонд байрлах “Зунжин” худалдааны төвийн талбайд 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр “Шар өвсөө шатаахгүй байя” өдөрлөгийг зохион байгуулж, галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр иргэдэд сэрэмжлүүлэг зөвлөмж өгөх, гарч болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг чанга яригчаар хүргэх, ой, хээрийн түймрийн үед ашиглагдаж байгаа техник хэрэгслийг таниулах, галын хор ашиглах</p>
9	100			

	<p>анхан шатны зөвлөмжийг хүргэн ажилласан. Өдөрлөгт гамшгаас хамгаалах сайн дурын 6 гишүүн, онцгой байдлын 5 алба хаагч, хорооны ажлын албанаас 10 ажилтан, 42 иргэд оролцсон. “Шар өвсөө шатаахгүй байя” аяны хүрээнд тус хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн бэлтгэл ээлжийн давхардсан тоогоор 147 алба хаагч, 21 удаа дүүргийн 17, 19, 23, 24 дүгээр хороодод хөдөлгөөнт эргүүлийн үүргийг гүйцэтгэж, 500 гаруй ширхгийг тарааж ажилласан.</p> <p>Ахуйн болон ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хүрээнд “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх”, “Ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх” постер 5, рийл сэрэмжлүүлэг 3 удаа байршуулан Онцгой байдлын Ерөнхий газрын цахим хуудаст 10, Нийслэлийн Онцгой байдлын газрын цахим хуудаст 10, нийт 20 удаагийн сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг Онцгой байдлын хэлтсийн цахим хуудсаар болон дүүргийн 1-24 дүгээр хороодын иргэдийн албан ёсны фейсбүүк групп рүү түгээж ажилласан. Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын баталсан “Дөрвөн асуудал-Нэг шийдэл” аяны хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын нийт 17 сургуулийн 1000 сурагч, 10 багш, 5 асран хамгаалагчдад “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулан ажилласан.</p>		
<p><b>Үүрэг, даалгавар ХОРИН НЭГ:</b> Нийслэлийн хэмжээнд үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг гадна орчноо угаах, өнгө үзэмжийг сэргээх, хог хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулах.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/354 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын нэгдсэн удирдамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг <b>“ДҮҮРГЭЭ ЦЭВЭРЛЭЦГЭЭ”</b> уриан доор долоо хоног бүрийн бямба гараг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, гуу жалганд үүссэн үүсмэл хог хаягдлыг цэвэрлэх, авто замын тэмдэг тэмдэглэгээ, цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбай, авто зам дагуух хайс хашлага, хөшөө дурсгалын өнгө үзэмжийг сэргээх, хөөстэй угаалга хийх, гэрлийн шонг бохирдуулж наасан зарлал, наалтыг хуулах, зэрэг ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.</p>		70
	<p><b>ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ</b></p>		83%

ТАНИЛЦСАН:  
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

О.БАТМӨНХ

НЭГТГЭЛИЙГ ХЯНАСАН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА




Т.БАТЦЭЦЭГ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.БУЯН-ӨЛЗИЙ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Б.ЖИНЧИНОРОВ

НЭГТГЭСЭН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

В.УРАНЧИМЭГ

